# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2022

ЗУУНМОД

# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

## 2022 онд Төрийн аудитын байгууллагын хэмжээнд дэвшүүлсэн зорилтын хүрээнд

Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт 39 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулж батлуулсан

Өнөөдрийн байдлаар 99,5 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажиллаж байна

## МУЕА-ын 2022 оны А/16 дугаар тушаалын хэрэгжилт

Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын дагуу

Байгууллагын дотоод ажлын төлөвлөгөөг 15 зорилтын хүрээнд 23 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулж батлуулсан

Өнөөдрийн байдлаар 99,6 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажиллаж байна

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны тайлан 2022 он

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГААС

## Хүний нөөц



**Тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 3, аудитор 7, жолооч 1, нийт 13 албан хаагч ажиллаж байна**

## Сургалт




***Үндэсний аудитын газрын ХБТГ-аас зохион байгуулсан Төрийн аудитын байгууллагын “Нэгдсэн сургалт-2022”-д 11 албан хаагч хамрагдан, сертификат авлаа. УАГ-аас зохион байгуулсан 38 удаагийн онлайн сургалтад албан хаагчид бүрэн хамрагдлаа***

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны тайлан 2022 он

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГААС

## 2022 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

- 196 — САНХҮҮГИЙН ТАЙЛАНД БИЕ ДААСАН ДҮГНЭЛТ ГАРГАСАН
- 161 — САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ТҮҮВЭРТ ХАМРУУЛЖ
- 2 — ТАЙЛАН АУДИТАД ХАМРАГДААГҮЙ

**НИЙТ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ**

- 7 БҮЛЭГ — НОТЛОХ АУДИТ
- 10 СЭДЭВ — ШУУД ТАЙЛАГНАХ АУДИТ
- 1 СЭДЭВ — НЭГТГЭЖ ТАЙЛАГНАХ

2022 оны гүйцэтгэсэн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил /сая төгрөг/







Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны тайлан 2022 он

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГААС

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ БОДЛОГО




ТАБ-ын Мэдээллийн технологийн талаарх бодлого чиглэлийг хэрэгжүүлэн ажиллалаа. Төрийн аудитын байгууллагын Хүний нөөцийн бүртгэлийн программ, ABLE программ, Оффис 365 программ, Санхүүгийн тайлангийн аудитыг fas.audit.mn систем, Судалгааны нэгтгэлийн client.audit.mn систем, Гүйцэтгэлийн аудитын data.audit.mn систем, Open.audit.mn нээлттэй портал сайт, Teams, Viber, audit.mn системүүдийг ашиглан ҮАГ-тай мэдээ, мэдээлэл солилцон, үйл ажиллагаандаа ашиглан ажиллалаа.

**Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 100 жилийн ойг угтаж 2022 онд хэрэгжүүлэх 20 бүтээлч ажил төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа**



Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛ




## ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

| Зардлын зүйл | Мөнгөн дүн /сая төгрөг/ |
|---|---|
| Цалин, НДШ | 495.7 |
| Хангамж бараа материал | 10.1 |
| Томилолт | 12.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | 7.9 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд | 1.9 |

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны тайлан 2022 он

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## Нийт 323 санхүүгийн тайлан аудитад хамрагдаж, 163 байгууллагын санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргасан.

### Санхүүгийн тайлангийн хамрагдалтын байдал







55 төсөвт байгууллага болон 103 тусгай сангууд, 2 орон нутгийн өмчит байгууллага, нийт 160 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан

**Зөрчилгүй дүгнэлт**
ТТЗ-ийн 23 санхүүгийн нэгтгэсэн тайлан
ТШЗ-ийн 119 санхүүгийн тайлан
ОНӨААТҮГ-ын 3 санхүүгийн тайлан

**Хязгаарлалттай санал дүгнэлт**
ТТЗ-ийн 2 санхүүгийн нэгтгэсэн тайлан
ТШЗ-ийн 10 санхүүгийн тайлан

**Сөрөг саналт**
ТШЗ-ийн 3 санхүүгийн тайлан

**Татгалзсан санал дүгнэлт**
ТТЗ-ийн 2 санхүүгийн нэгтгэсэн тайлан
ТШЗ-ийн 1 санхүүгийн тайлан
ОНӨААТҮГ-ын 1 санхүүгийн тайлан

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын тайлан /2022 он/


Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

"УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ" ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

# Улсын төсвийн хөрөнгө оруулалт /салбараар/




Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль"-иар Төв аймагт 8 ТЕЗ-аас 41,865.8 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээр жагсаалтаар батлагджээ.




2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр ТЕЗ-дад хүргэгдсэн 11 саналаас жагсаалтад батлагдсан эрүүл мэнд, боловсролын салбарын 3,733.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн ИТХТ-ийн 41 дүгээр тогтоолын нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна




Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# “УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шилжих төсөл арга хэмжээний төлөвлөлт




Аймгийн ТЕЗ-д эрх шилжин хэрэгжиж байгаа 13 ажлын 6 ажил нь их засвар, 7 нь шинээр баригдах барилга, байгууламж байна. Үүнээс 11 ажлын зураг, төсвийг зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж гүйцэтгүүлэн, МЕД-ээр баталгаажуулахаас шинээр баригдаж буй нэг барилга батлагдсан зураг төсөвгүй хэрэгжиж байна

## ИТХТ-ИЙН 41 ДҮГЭЭР ТОГТООЛЫН НЭГДҮГЭЭРТ ЭРЭМБЭЛЭГДСЭН 3 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ БАЙНА.

| Төсөл арга хэмжээ | Төсвийн ерөнхийлөн захирагч | Төсөвт өртөг /сая төгрөг/ |
|---|---|---|
| Угтаалцайдам сумын цэцэрлэгийн барилга | БШУС | 1,300.0 |
| Хүмүүн цогцолбор сургуулийн хичээлийн А байрны их засвар | БШУС | 733.6 |
| Баянцогт сумын ЭМТ-ийн барилга | ЭМС | 1,700.0 |

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
### /эх үүсвэрээр/



100 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, хөтөлбөрт 12,159.7 сая төгрөг




20 төсөл, арга хэмжээ 752.5 сая төгрөг

13 төсөл, арга хэмжээ 682.0 сая төгрөг

11 төсөл, арга хэмжээ 3,500.0 сая төгрөг

56 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ 7,225.2 сая төгрөг

*Батлагдсан төсөл арга хэмжээний дийлэнх нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн* байдал

| Төсөл арга хэмжээний эх үүсвэр | Үндэслэсэн эх сурвалж |
|---|---|
| **Шилжих үлдэгдэл** | мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт |
| | Сум орон нутгийн хэрэгцээ шаардлага |
| **Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан** | 10 төсөл, арга хэмжээ нь БОАЖГ-ын саналаар |
| | 10 төсөл арга хэмжээ нь Аймгийн ИТХ болон судалгаа |
| **Замын сан** | замын ашиглалтын бэлэн байдлын үзлэг, авто зам, |
| | сумын ЗДТГ, аймгийн замын цагдаагийн тасгаас санал |
| **Орон нутгийн хөгжлийн сан** | Эрэмбэлэгдсэн жагсаалт |
| | Сумын ИТХ, ЗД-ын санал |

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/


Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр

**ОНХНС-аас**
**9,333.7 сая төгрөг**

**Нийт эх үүсвэр 10,559.7 сая төгрөг**

**Бусад**
**1,050.0 сая төгрөг**

Аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилт /сая.төг/





Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/



Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## Төв аймагт үйл ажиллагаа явуулдаг ОНӨААҮГ-ын бүртгэл




## Орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

| Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн | 2019 он | | 2020 он | | 2021 он | |
|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Аймгийн Автотээврийн төв | 350,561.6 | 762,829.3 | 377,449.4 | - | 390,952.4 | 726,184.6 |
| Төв Чандмань ДЭХГ | 6,559,100.0 | 6,843,700.0 | 7,083,600.0 | 7,510,600.0 | 7,867,400.0 | 8,147,700.0 |
| БЗОСК | 353,680.0 | 188,080.2 | 324,400.0 | 196,645.9 | 380,244.5 | 360,400.0 |

## Орлогын тайлангийн бүтцийн шинжилгээ

| Үзүүлэлт | Төв Автотээврийн төв | | Төв Чандмань ДЭХГ | | | БЗОСК | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2019 он | 2021 он | 2019 он | 2020 он | 2021 он | 2019 он | 2020 он | 2021 он |
| Борлуулалтын орлого | 762,829.3 | 726,184.6 | 6,807,081.8 | 7,474,936.1 | 7,916,831.0 | 167,220.1 | 196,645.9 | 167,220.1 |
| Бусад орлого | | | 38,475.8 | 35,645.3 | 230,903.3 | | | |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 319,453.8 | 391,617.2 | 6,713,508.2 | 7,515,192.9 | 7,565,512.0 | | | |
| Удирдлага, үйл ажиллагааны зардал | 262,898.7 | 277,391.9 | 248,428.5 | 238,447.6 | 445,158.0 | 168,311.6 | 166,220.7 | 169,479.9 |
| Цэвэр ашиг | 180,476.8 | 57,175.5 | (116,379.1) | (243,059.1) | 137,064.3 | (1,091.5) | 30,425.2 | (2,259.8) |
| Нийт ахиуц ашиг | 0.58 | 0.46 | 0.01 | (0.01) | 0.04 | 1.00 | 1.00 | 1.00 |
| Үйл ажиллагааны ахиуц ашиг | 0.34 | 0.38 | 0.04 | 0.03 | 0.06 | 1.01 | 0.85 | 1.01 |
| Цэвэр ахиуц ашиг | 0.24 | 0.08 | (0.02) | (0.03) | 0.02 | (0.01) | 0.15 | (0.01) |

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТҮГЭЭМЭЛ ТАРХЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАЙДАЛ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАЙДАЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл

МУЕА-ын 2022 оны А/11, А/12 дугаар тушаалууд

Төв аймаг дахь ТАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ



ТТАМ-ын тусгай зөвшөөрөл олголт, нөхөн сэргээлтийн байдлыг ТТАМ-ын тухай хууль хэрэгжиж эхэлсэн хугацаа буюу 2016-2022 оны байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, эрдэс баялгийн байнгын зөвлөл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл, аймаг, сумдын Засаг дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар болон холбогдох бусад байгууллагуудыг хамруулан аудит хийв.

## ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАЙДАЛ

### ТТАМТЗ эзэмшигчийн судалгаа

| № | Сумын нэр | БҮГД | | Ашиглалтын ТЗЭ | | Хайгуулын ТЗЭ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТЗЭ-ийн тоо | Талбайн хэмжээ | Бүгд | Талбайн хэмжээ | Бүгд | Талбайн хэмжээ |
| 1 | Алтанбулаг | 34 | 1,648.10 | 21 | 863.57 | 13 | 784.53 |
| 2 | Аргалант | 2 | 129.80 | | | 2 | 129.80 |
| 3 | Архуст | 1 | 370.00 | | | 1 | 370.00 |
| 4 | Баян | 1 | 64.38 | | | 1 | 64.38 |
| 5 | Баяндэлгэр | 1 | 29.81 | | | 1 | 29.81 |
| 6 | Баянцогт | 1 | 100.00 | | | 1 | 100.00 |
| 7 | Баянчандмань | 2 | 54.00 | 1 | 27 | 1 | 27 |
| 8 | Заамар | 2 | 175.71 | | | 2 | 175.71 |
| 9 | Сэргэлэн | 17 | 1,964.39 | 4 | 495.88 | 13 | 1,468.51 |
| 10 | Эрдэнэ | 7 | 914.11 | 1 | 150.29 | 6 | 763.82 |
| | Нийт | 68 | 5,450.30 | 27 | 1,536.74 | 41 | 3,913.56 |

Эдгээрээс 12 ААН нь үйл ажиллагаа явуулж байна.




2016 оноос өмнө АМГТГ-аас

13 ААН-д 677.67 га талбайд

Аймгийн Засаг даргын захирамжаар

14 ААН-д 859.07 га талбайд

Аймгийн хэмжээнд нийт

27 ААН-д 1,536.74 га талбайд

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, нөхөн сэргээлтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС







**Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан нэр төрлийн орлого давж орсон тохиолдолд тогтоосон хувь хэмжээгээр байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилах зохицуулалтгүйгээс давсан орлогыг төсвийн урсгал зардалд зарцуулж байна.**

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА

**Төв аймаг дахь Төрийн аудитын газрын санал:**

Аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг **10,843.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэх

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд 4 нэр төрлийн орлогыг **2,178.5 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх

1. Ус ашигласны төлбөрийг 2022 оны ногдуулалтаас дутуу тооцсон 1,408.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
2. Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлогыг аймгийн ИТХ-аас Орон нутгийн өмч хөрөнгийг худалдан борлуулах талаар гаргасан шийдвэрүүдээс худалдан борлуулагдаагүй хөрөнгийн үлдэгдлийг тооцсоноор 670.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
3. Түрээсийн орлогыг "Нэгдсэн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба"-ны байранд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
4. Улсын тэмдэгтийн хураамжийг Хөшгийн хөндийн шинэ онгоцны буудал ашиглалтад орж виз олгох хураамжийн орлогыг тооцсоноор 90.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх

ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА

**Төв аймаг дахь Төрийн аудитын газрын санал:**

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд 48,325.6 сая төгрөгийн зарлагыг 7 нэр төрлийн 1,044.2 сая төгрөгөөр бууруулж, нийт зарлагыг 47,281.4 сая төгрөг болгох боломжтой байна.

**Төсвийн зарлага бууруулах санал**

- *Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, орон тоо бүтэцийн зарлагыг аймгийн ЗД-ын орлогч, зөвлөхийн орон тоог нэг болгон 19.9 сая төгрөгөөр бууруулах*
- *Шуудан холбооны зарлагыг өмнөх түвшингээс өсгөхгүй 26.2 сая төгрөгөөр бууруулах*
- *Бичиг хэргийн зарлагыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үндэслэн 23.2 сая төгрөгөөр бууруулах*
- *Тээвэр шатахууны зарлагыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үндэслэн 32.8 сая төгрөгөөр бууруулах*
- *13 байгууллагын урсгал засварын зардлыг 27.8 сая төгрөгөөр хэмнэх*
- *Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үндэслэн 104.3 сая төгрөгийн зардлыг бууруулах*
- 810.0 сая төгрөгийн 6 ажлын зураг, төсөв хийгдээгүй тул хөрөнгө оруулалтын зардлаас хасах

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Төв аймгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА

Сумдын орон нутгийн төсөвт 9 нэр төрлийн орлогыг **8,665.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх

- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулан тооцсоноор 15.8 сая төгрөгөөр
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төсвийн төсөлд иргүүлж хянуулсан баримтуудаас түүвэрлэн тооцоход 84.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийг 2020 оноос хойш төлөвлөөгүй байхад 2020 онд 1.5 сая төгрөг, 2021 онд 0.2 сая төгрөг, 2022 онд 1.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Иймд тус орлогыг энэ оны түвшинд буюу 1.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
- Газрын төлбөрийн орлогыг өмнөх оны дутуу төлөлтөөс 605.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн 2022 оны ногдуулалт болон тайлант оны дутуу төлөлтөөс 4,609.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
- Түрээсийн орлогыг тооцооллын дагуу 18.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
- Галт зэвсгийн албан татварыг Цагдаагийн газраас ирүүлсэн судалгаа, ногдуулалтын дагуу 1.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
- Малын тоо толгойн албан татварыг өнгөрсөн 2022 оны мал тооллогын дүнг үндэслэн ногдуулалт хийж тооцож үзэхэд сумдын төсөвт 2,329.2 сая төгрөг төвлөрүүлэх
- 2022 оны батлагдсан төлөвлөгөө 900.0 сая төгрөг, ХБГ-ээр 1,110.0 сая төгрөг байна. Тус орлогыг УИХ-аар нэг тэрбум төгрөгөөр баталсныг аймгийн 2023 оны төсвийн төсөлд хасаж тооцсоныг үндэслэлгүй гэж 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулах

ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА




## Зөвлөмж

2023 оны 6 дугаар сарын 20-ны дотор хэрэгжилт гаргах

- Аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын нэр төрөл бүрээр ногдуулалтыг хийж, орлогыг бодитой төлөвлөх, хураан барагдуулах, тайлан мэдээ гаргах талаар үр дүнтэй ажил зохион байгуулах
- Аймгийн хэмжээний татварын дутуу төлөлтийн мэдээ, тайланг нэгтгэн гаргах, барагдуулах, холбогдох байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангахад анхаарч ажиллах
- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа, зардалд тавих хяналтыг сайжруулах замаар төрийн бүх шатны байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх
- Засгийн газрын 2023 оны төсвийн төсөлд баримталсан бодлогын арга хэмжээний дагуу төсөвт байгууллагын тэвчиж болох урсгал зардлыг 50 хувиар, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлыг 30 хувир тус тус бууруулан хэмнэж ажиллах
- Бүх шатны төсөвт байгууллагын албан бичиг хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэн, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх замаар холбогдох зардлыг хэмнэх
- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах
- Төсвийн шилжих үлдэгдлийг санхүүгийн жил дуусаж төсвийн болон санхүүгийн үйл ажиллагааны тайлан гараагүй байхад хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр тооцоо хийж байгаа нь Төсвийн хуультай нийцэхгүй, дараагийн хуралдаанаар батлуулж байх
- Газрын дуудлага худалдааны орлогыг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.11-д "Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна" гэсэн заалтыг мөрдөж орон нутгийн төсөвт төвлөрүүлэлгүй, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулдаг байдлыг таслан зогсоох

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Төв аймгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582 мейл хаяг: tuv@audit.mn

# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр**: 2016 оны 2 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан.

**Хэрэгжүүлэх хугацаа**: 2017 оноос эхлэн 4 жилийн хугацаатай 2 үе шаттай

**Хэрэгжилтийг үнэлсэн байдал**: 1-р үе шат "Бүрэн хэрэгжсэн"; 2-р үе шат "Тодорхой үр дүнд хүрсэн



| Санхүүжилтийн эх үүсвэр | |
|---|---|
| | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан |
| | Аймаг хөгжүүлэх сан |
| | Сум хөгжүүлэх сан |
| | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан |

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД 2016-2021 ОНУУДАД БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТ /САЯ.ТӨГ/




2016-2021 онуудад ХЭДС, АХС,- СХС, ЖДҮДС-уудаас 33,593.2 сая төгрөгийг зарцуулсан.

ХХҮГ-аас 2016-2021 онуудад → 6093 иргэнд сургалт, зөвлөгөө өгч → 4550 иргэнд ажлын байр санал болгосноос → 4543 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна. → Аймгийн хэмжээний ажилгүй иргэдийн нэгдсэн судалгаа байхгүй байна.

4 МСҮТ-д 5034 суралцагч элсүүлснээс 4350 төгсөж 1178 төгсөгч ажлын байраар хангагдаагүй байна.

*Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчийн оролцоотой 84 байгууллагад 98 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна*

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-т заасныг зөрчсөн байна. ХЭДС-нд 2016-2021 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрт 184 хүний 489.0 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд 2,671.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын газар Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /2022 он/

Төр захиргааны 2 дугаар байр, Зуунмод сум, Төв аймаг, Монгол улс
Утас: 70272582   мейл хаяг: tuv@audit.mn